

## ШИНЭ ХЭВИЙН БАЙДАЛ ДАХЬ ХЯТАД, МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГ ХАНДЛАГА

*Б.Хөгжилт\**

***Abstract:** Foreign economic policy is the extension of domestic economic policy. China's entry into its new normal stage foretells new idea, pattern and model of its foreign relations. "The belt and road" strategic policy of China provides good opportunities of development for the countries and regions along the route. This paper tries to find out the new understanding, idea, major industries, trends of investment and finance, and regional integration of Sino-Mongolian cooperation in economic field after China enters the new normal stage.*

***Key words:** The New Normal, Sino-Mongolian Economic Cooperation*

\* \* \*

2014 оны 5 дугаар сард Хятад Улсын дарга Ши Жиньпин Хятадын Хэнань мужид судалгаа хийх үеэр, манай улсын хөгжил ч мөн адил чухал бодлого явагдаж байгаа учраас одоогийн Хятадын эдийн засгийн хөгжлийн үе шат, үндсэн зарчмуудыг шингээсэн байх хэрэгтэй гэв. Энэ бол Хятадын удирдагч анх удаа шинэ мөчлөгийн эдийн засгийг “шинэ хэвийн байдлаар” дүрсэлсэн хэрэг юм.<sup>199</sup>

Ер нь Хятадын эдийн засгийн шинэ хэвийн байдал нь дөрвөн гол болох онцлогтой. Үүнд:

1. Өндөр хурд: эдийн засгийн эрчимтэй өсөлтийн хурдыг удаашруулж, өмнөх 10 орчим хувиас 7-8 хувийг нь, дунд өндөр хурдад шилжүүлэх бол шинэ хэвийн байдлын хамгийн үндсэн онцлог мөн.
2. Бүтэц шилжүүлэх: эдийн засгийн бүтцийн талаар, үйлчилгээний салбарыг үе шаттайгаар эдийн засгийн гол салбар болгоно. Эрэлт хэрэгцээний талаар, хэрэгцээг үе шаттайгаар хэрэгцээний гол субъект болгоно. Хот, хөдөөгийн бүсийн талаар, хот хөдөөгийн ялгааг үе шаттайгаар багасгана. Орлогын хуваарилалтын бүтцийн талаар, оршин суугчдын орлогын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.
3. Шинэ түлхэц: Хөрөнгө оруулалт, хүчин зүйлд тулгуурлаж байсан Хятадын эдийн засгийг инновацид тулгуурладаг болгох.
4. Олон сорилт: Зарим тодорхой бус байдлын эрсдэлүүд ил бус байдлаар илэрч байх. Тухайлбал орон сууцны зах зээл, орон нутгийн өр, банк санхүүгийн гэх зэрэг эрсдэлүүд.

Шинэ хэвийн байдал бол эдийн засгийн салбарт зориулж дурдсан үзэл баримтлал, гэхдээ Сингапурын “үүсгэн байгуулагч” Lee Kuan Yew Хятадын

\* ӨМИС-ийн Монгол судлалын төвийн ахлах судлаач.

<sup>199</sup> 主席在河南考察首次明确提出新常态 - ROM之家网, <http://www.romzj.cn/news/games/168/20160305/48932/>

гадаад харилцааг хэлэхдээ: “эдийн засгийн хүчин зүйл, үндсэн чиг хандлагыг тодорхойлов”<sup>200</sup> гэж хэлсэнчлэн, сүүлийн жилүүдэд, Хятадын эдийн засаг шинэ хэвийн байдалд шилжихийн хэрээр, Хятадын эдийн засгийн гадаад харилцаанд мөн шинэ нэр томъёо, үзэл баримтлал, загварууд бий болсоор байна.

Шинэ нэр томъёо, ойлголт, үзэл баримтлалын талаар “хөршүүдийн хувь заяаны хамтын нийгэмлэг”, “дотоно, үнэнч, хүртээмж, багтаамж”-тай хөршийн бодлого, “нэг бүс нэг зам”, “харилцан холболт”, “өндөр хурдны төмөр замын гадаад харилцаа”, “эдийн засгийн коридор”, “нээлттэй дэлхийн эдийн засаг”, “Ази Номхон далайн чөлөөт худалдааны бүс” зэрэг Хятадын ойлголт эрчимтэй тархаж байна. Техник хангамжийн хамтын ажиллагааны талаар, “өндөр хурдны төмөр зам” нь “Хятад үйлдвэрлэв”-ийн нэрийн хуудас болж, түүний олон улсын үйлдвэрлэлийн гинжин дэх байр суурь өндөржсөнийг тодорхойлж буй юм. Эдгээр хувиралт нь Дэлхийн банкны тэргүүлэх эдийн засагч асан Лин и-фүгийн хэлсэнчлэн, бүх хөгжиж байгаа улс оронд аж үйлдвэржилт, өргөжин тэлэх гэгээвчийн хугацааг олгосон гэмээр. Хятадын “Нэг бүс, Нэг зам”-ын санаачлагад оролцсоноор Хятадын өнгөрсөн 30 жилийн өндөр хурдыг гүйцэх боломжтой.<sup>201</sup> Эдийн засгийн гадаад харилцаа нь Хятадын эдийн засгийн орон зайг өргөжүүлж, мөн ёс суртахууны хувьд Хятадын хариуцлагатай том гүрний дүр төрхийг харуулдаг. Хятад нь эдийн засгийн арга хэрэгслээр дэлхийтэй харилцах явцдаа эдийн засгийн ашгаас гадна, Хятадын хэлбэр, Хятадын өнгө төрх, хэв маяг, дэлхийн энх тайван болон хамтын хөгжлийг хамгаалах, нэн зүй зохистой олон улсын эдийн засгийн дэглэм бий болгохыг чухалчилсан бөгөөд санал дэвшүүлсэн.

2014 оны 8 дугаар сард Хятадын дарга Ши Жиньпин Монгол улсад айлчлах үеэр, Хятад болон хөгжиж байгаа улсуудын хамтын ажиллагааг хэлэхдээ, зөв ёс ба ашгийн үзэл баримтлал, би хожиж чи хожигдох, би илүү чи дутуу гэсэн ажлыг хийхгүй. Мөн бусад улс орон Хятадын хөгжлийн хурдны галт тэргэнд эсхүл таарсан тохиромжтой тэргэнд хамт суухад бэлэн байж, харилцан ашигтай хамтдаа хожлыг авцгаая гэж уриалав.<sup>202</sup> “Нэг зам, Нэг бүс”, шинэ ойлголт, эдийн засгийн шинэ хэвийн байдлын нөлөөгөөр дэлхийн улс төр, эдийн засгийн шинэ дэглэм бүрэлдэн тогтож, үүнд Хятад илүү голлох үүрэг гүйцэтгэх болсон.

Монгол улсын эдийн засгийн хувьд, уул уурхайд хэт тулгуурласан, хөдөө аж ахуй эрчимжээгүй, урт хугацааны санхүүгийн тэлэх бодлого явуулсан, дэлхийн зах зээлийн түүхий эдийн үнийн уналт зэргээс шалтгаалан, сүүлийн жилүүдэд эдийн засгийн уналт эрчимжиж, 2015 оны ДНБ-ний өсөлт 2.4 хувь байгаа нь өнгөрсөн оныхоос 5.5 хувиар буурч, 2016 онд 1.2 хувь болж буурав. Энэ нь дэлхийн санхүүгийн хямралын нөлөөгөөр 2009 онд -1.3 хувь<sup>203</sup> болж буурсан нь сүүлийн үеийн доод үзүүлэлт бөгөөд хямралын ирмэгт хүрсэн гэж дүгнэж болохоор байна.

<sup>200</sup> 中国经济外交新常态之一：经济外交开启中国范式 - 国际频道 - 新华网  
[http://news.xinhuanet.com/world/2014-12/25/c\\_1113771608.htm](http://news.xinhuanet.com/world/2014-12/25/c_1113771608.htm)

<sup>201</sup> Дээрхтэй адил.

<sup>202</sup> 习近平在蒙古国国家大呼拉尔发表重要演讲--时政--人民网 .  
<http://politics.people.com.cn/n/2014/0823/c1024-25522723.html>

<sup>203</sup> Монгол улсын үндсний статистикийн хөрөө, <http://www.1212.mn/statHtml/statHtml>.

Түүнчлэн 2009 оны хямрал нь олон улсын төлбөрийн тэнцлийн алдагдлаар гол шинжтэй байсан бол, эдүгээ харин төлбөрийн болон төсвийн гэсэн хос алдагдлын шинжтэй болсон байна. Олон улсын уул уурхайн бүтээгдэхүүний үнийн уналтын мөчлөг дуусах хязгаар харагдахгүй өнөөгийн байдалд, Монгол улс нь санхүүгийн болон мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлэх, хууль зүйн орчин болон бодлогын тогтвортой байдлыг сайжруулах, “хөгжлийн зам” төслөө Хятад, Оросын төсөл санаачлагатай сайтар уялдуулах замаар одоогийн эдийн засгийн хүндрэлийг даван туулж, ирээдүйн зах зээлийн болон эдийн засгийн төрөлжилтөд бат бэх суурь тавих нь чухал.

Хятад, Монгол хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаанд, газарзүй, хүмүүнлэг, эдийн засгийн нөхөх байдал гэх зэрэг бусдаас хамаагүй давуу тал байдаг. Хятадын худалдааны яамны мэдээлснээр, 2017 оны 6 дугаар сар хүртлэх Хятадын Монгол дахь банк санхүүгийн бус шууд хөрөнгө оруулалт 4.1 тэрбум ам.доллар байж, ГШХО-ын нийт дүнгийн 30 хувийг эзэлж, хоёрдугаар байранд байна гэсэн байна. 2016 оны Хятад Монголын худалдааны эргэлт 4.92 тэрбум ам.доллар болж, Монголын экспортын 79 хувь, импортын 31 хувь<sup>204</sup>-г эзэлж, худалдааны нэгдүгээр түнш хэвээр байна.

Хятад, Монголын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны гол салбарууд нь уул уурхайн ашиглалт, дэд бүтцийн бүтээн байгуулалт гэж тодорхойлогдож байсан бол, 2008 оноос уул уурхайн ашиглалт, дэд бүтцийн бүтээн байгуулалт, санхүүгийн хамтын ажиллагаа, гурвыг уялдуулан цогцоор хөгжүүлэх нь зүйтэй гэж үзэв. Хятадын эдийн засгийн шинэчлэлийн үед хоёр орны иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа эрчимжихээс гадна “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор байгуулах төлөвлөгөөний хөтөлбөр” хэрэгжихийн хэрээр хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаанд шинэ ойлголт, гол салбар, хөрөнгө санхүүжилтийн чиглэл, бүс нутгийн хамтын ажиллагааны хэлбэр, интеграцийн чиг хандлагууд ажиглагдаж байна.

**Нэг. Хамтын ажиллагааны ойлголтод Хятадын эдийн засгийн шинэ хэвийн байдлын онцлог, хөршийн бодлого, шинэ ёс ба ашгийн үзэл нэн бодитоор тусгагдах болно.**

Хятад, Монголын эдийн засгийн хамтын ажиллагаа, ялангуяа томоохон төслүүдэд саад учирч байсан нь ихэвчлэн Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын эдийн засгийн түшилцэх харилцаанд хязгаар тогтоосон заалт, “гуравдагч хөршийн” бодлогын сонголтын бэрхшээл, үйлдвэрлэгч болон худалдан авагч нь нэг этгээд байвал Монголын талд ашиггүй гэсэн эмзэглэл хийгээд Хятадын компанийн эдийн засгийн ашгийг давамгайлсан менежментийн үзэл, хэлбэрүүдээс шалтгаалж байсан.

Хятадын эдийн засгийн шинэ хэвийн байдал нь бүтцийн шилжилт, шинэ түлхэц, ногоон хөгжил, экологийн соёл иргэншлийг чухалчилж, Хятадын гадаад

<sup>204</sup> Монгол улсын гаалийн ерөхий газар, 2016 оны 12-р сарын гадаад худалдааны эмхитгэл, Online Statistic Information System. [http://mram.gov.mn/mram\\_new/images/stories/mram/statistek/2015/monthly\\_report\\_2016.01.04.pdf](http://mram.gov.mn/mram_new/images/stories/mram/statistek/2015/monthly_report_2016.01.04.pdf).

бодлогын чиглэлд хөршийн бодлогын байр суурь дээшилж, “дотоно, үнэнч, хүртээмж, багтаамж”-тай, оновчтой, ёс ба ашгийн үзэл, “хөршийн хувь заяаны хамтын нийгэмлэг”-ийн үзэл баримтлал хэрэгжүүлж байгаа, “Нэг бүс, Нэг зам”-ын санаачлагад хамтаар зөвшилцөх, байгуулах, хуваалцах зарчим ба ойлголт<sup>205</sup> дэвшүүлсэн. “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор” байгуулах талаар гурван орны төрийн тэргүүн чухал тохиролцоонд хүрсэн нь 2 орны эдийн засгийн хамтын ажиллагаанд шинэ ойлголт, үзэл баримтлал, зарчмууд нэмэгдэж чухал үлгэр жишээний ач холбогдол бүхий “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор” байгуулахад Монгол улсын нэн чухал ашиг сонирхол, тухайлбал дэд бүтцээ хөгжүүлж, дамжин өнгөрөх тээврийн хэмжээгээ нэмэгдүүлэх, эдийн засгаа төрөлжүүлэх, гуравдагч зах зээлтэй болох, эдийн засгийн тусгаарлагдмал байдлаа сааруулах зэргийг харгалзах нь эргэлзээгүй.

Мөн хоёр том хөршийн ижил чиглэлийн хүчин чармайлт нь бүс нутгийн энх тайван ба хөгжилд тогтвортой хүчин болж, гурван улсын нягт хамтын ажиллагаа нь гурван талын геополитик, гео-эдийн засгийн ашиг сонирхлыг улам бүр уялдуулан нэгтгэж, Монгол талын зарим эрсдэлийг сааруулахад таатай гадаад орчныг бүрэлдүүлж байна.

### **Хоёр. Томоохон төслийн хамтын ажиллагааны давуу тал**

Дэд бүтэц, уул уурхайн ашиглалтыг багтаасан асар их бүтээн байгуулалт бол XXI зууны эхэнд Монгол улсын тогтоосон мянганы зорилтуудын чухал бүрэлдэхүүн хэсэг болно. “Баяжъя гэвэл замаа засаарай” гэдэг бол Хятадын туршлага. Монгол шиг дэд бүтэц сул далайд гарцгүй, зөвхөн дэд бүтцээ сайжруулснаар эрдэс баялгийн нөөцөө нэн сайнаар ашиглах, хөдөө аж ахуй, аялал жуулчлалыг багтаасан холбогдох салбаруудыг хөгжүүлэх, эдийн засгаа солонгоруулах зорилтод хүрч чадна. Дэд бүтэц, томоохон уул уурхайн ордын ашиглалт нь томоохон төслөөс ангижирч дийлэхгүй. Улс хоорондын хамтын ажиллагаа нь мөн адил томоохон төслөөс ангижирч дийлэхгүй. Томоохон төсөл бол засгийн газар хоорондох хамтын ажиллагааны олон улсын жишиг байж, хоёр талын буюу олон талын хамтын ажиллагааг ахиулах бүтээмжтэй хэрэгсэл юм. Ер нь засгийн газар тавцан байгуулж, том аж ахуй нэгжүүд хэрэгжүүлдэг. Учир нь том компанийн хөрөнгө, технологи, менежментийн хүч чадал ихтэй, тэдий үйлдвэрлэлийн байрлуулалт нэн холыг харсан байж, харьцангуйгаар Монголын эдийн засгийн хэтийн зорилтод амархан нийцэж, мөн тэдний үйл ажиллагаа зорилтыг амархан дүрэмжүүлж, Хятад Монголын хамтын ажиллагаанд үлгэр жишээн үүргийг гүйцэтгүүлж чадах юм.

Гэхдээ томоохон төслийн хэрэгжилтэд, Хятадын компани нь юуны түрүүнд Монголын байдалд үл нийцэх менежментийн ойлголт, загвараа таягдсан байх хэрэгтэй. Юуны өмнө, 100 хувийн хөрөнгө оруулалт, холдинг эзэмшил зэрэг сэтгэхүйг заавал таягдсан байж, Монголын ашиг сонирхол, одоогийн хүчин

<sup>205</sup> нээлттэй хамтын ажиллагаа, эе зохицол хүлцэлтэй, зах зээлээр ажиллах, харилцан ашигтай хамтдаа хожих, хамтран байгуулах зарчим, бодлогын уялдалцал, дэд бүтцийн холболцол, худалдааны нэвтрэлцэл, хөрөнгийн санхүүжлэл, иргэний ойлголцлын гол агуулга, энх тайван хамтын ажиллагаа, нээлттэй хүлцэлтэй, харилцан суралцаж харилцан зээлдэх, харилцан ашигтай хамтдаа хожих ойлголт.

төгөлдөр хэрэгжиж байгаа хууль тогтоомжийн дагуу, Монгол талтай хамтарсан буюу гуравдагч талтай хамтын ажиллагааны боломжийн хэлбэрийг сонгох хэрэгтэй. Үнэндээ ямар ч хэлбэрийн хамтын ажиллагаа байсан, эцсийн зорилтот зах зээл нь асар том Хятадын зах зээлийг гүйцэхгүй. Түүнчлэн ашиглалтын логистик аж ахуйн ажил хүртэл Хятадаас ихэвчлэн хамааралтай байж, тэртэй тэргүй Хятад бол хилийн чанад дахь хамгийн их ашиг хүртэгч болно. Хоёрт, Монголын үндэсний аж үйлдвэр байгуулах, төрөлжүүлэх зорилтыг ойлгон, төслийн хэрэгжилтэд үндэсний үйлдвэрлэлийн, нийгмийн, экологийн үр ашгийг сайтар харгалзсан байх хэрэгтэй. Гуравт, үндэстэн дамнасан аж ахуйн нэгжийн соёлын түвшингээ дээшлүүлж, “нутагшуулсан” менежмент хэрэгжүүлж, нийгмийн хариуцлагаа дээшлүүлсэн байх шаардлагатай.

Засгийн газар болон аж ахуйн нэгжийн хоёр түвшинд шинэ хэвийн байдал ба “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор”-ын үзэл баримтлал, ойлголтыг жинхэнэ утгаар хэрэгжүүлбээс, томоохон төсөл нь Монголын эдийн засаг, нийгмийн хөгжилд асар их ногдол ашгийг бий болгон, Монгол болон хөрш зарим оронд байгаа хардлага эмзэглэлийг тайлж, түүний хэрэгжих үйл явцыг ихэд түргэсгэж болох юм.

### **Гурав. Санхүүгийн тэргүүлэх үүрэг эрчимжих:**

Монголын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хөрөнгө мөнгө их бөгөөд эдийн засгийн коридорт энэ салбарын хамтын ажиллагаа нэн тэргүүнд хөгжих шаардлагатай. Үүнээс гадна, уул уурхайн эрчим хүчний томоохон төсөл, хөдөө аж ахуйн боловсруулах салбар, аялал жуулчлал, байгаль орчны хамгаалалт, бүс нутаг ба хил орчмын хамтын ажиллагаанд мөн их хэмжээний гадаад хөрөнгө татах шаардлагатай.

“Нэг зам, Нэг бүс” санаачлагын дэд бүтэц, томоохон төслийн бүтээн байгуулалт дахь санхүүгийн тэргүүлэх үүргийг бүрэн гүйцэтгэх үүднээс, Хятадын засгийн газар санаачлан, АДБХОБ болон ТЗС байгуулсан. Мөн сүүлийн үед, олон улсын санхүүгийн зарим байгууллага, Хятадын хэд хэдэн томоохон банкууд тус санаачлагад оролцохоо мэдэгдээд байгаа. Монгол улс нь АДБХОБ-ны анхны үүсгэн байгуулагч ба чухал төсөл хэрэгжүүлэгчийн хувьд, Эдгээр санхүүгийн байгууллагаас хувьцааны эрхийн хөрөнгө оруулалт, өрийн эрхийн хөрөнгө оруулалт, зээл, баталгаа олгох зэрэг хэлбэрээр дэд бүтцийн бүтээн байгуулалтад санхүүгийн дэмжлэг авч болно. Мөн Монгол улс нь ШХАБ-ын ажиглагч орны хувьд, тус байгууллагын хүрээнд санхүүгийн хамтын ажиллагаанд оролцох боломжтой.

Хятад, Монголын эдийн засгийн хамтын ажиллагааны гол салбарын нэг болох санхүүгийн хамтын ажиллагаанд шинэ дэвшил харагдаж байна. Тухайлбал Хятадаас Монголд үзүүлэх зээл тусламжийн хэмжээ улам бүр нэмэгдэж, хоёр талын үндэсний валютын своп хэлэлцээр амжилттай хэрэгжиж, банк санхүүгийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа өргөжин, “Хятадын банк”, “Хятадын аж

үйлдвэр худалдааны банк” зэрэг Хятадын томоохон банк Монголд төлөөлөгчийн газраа нээж, салбар байгуулахаар ажиллаж байна.<sup>206</sup> Үүнээс гадна, “Өвөр Монгол банк”, “Бугатын худалдааны банк” зэрэг орон нутгийн банкууд Монголын зах зээлд орох үйл явц явагдаж байгаа, “Хятадын банк”-ийн Монголд суугаа төлөөлөгчийн ярьснаар, түүний голлох үйл ажиллагаа нь Хятадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн Монгол дахь томоохон төсөлд зээл болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэхэд орших юм.

Хятадын гадаад валютын нөөц их, ААН-ийн хөрөнгө санхүүгийн хүчин чадал нэмэгдэж, 2015 онд гадаад дахь ГШХО-ны хэмжээгээр дэлхийд 2-рт орж, анх удаа цэвэр капитал гаргах улс болж, “Нэг зам, Нэг бүс”-ийн дагуух улс орнууд дахь хөрөнгө оруулалтын оны өсөлт 38.6 хувь хүрч, Хятадын дундаж өсөлтөөс 2 дахин их байгаа бөгөөд түүний 70 хувь нь Азийн улс оронд орсон болно.<sup>207</sup> Энэ нь Хятадын ААН-ийн олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаанд гүйцэтгэх үүрэг роль улам бүр өсөн нэмэгдэж байгааг харуулж байна. Гадаад хөрөнгө татах талаар Монголын шинэ засгийн газар өмнөх туршлагаа дүгнэж, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, банк санхүү, төсвийн системийг тогтвортой болгох, өрийн эрсдэлийг сааруулахад дорвитой арга хэмжээ авч байгаа нь ГШХО-д нааштайгаар нөлөөлөх болно. Одоогийн хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа, коридор байгуулах үйл явц эрчимжихийн хэрээр бэхжиж банк, санхүүгийн салбарын хамтын ажиллагаа зүг чигээ олж, өөрийн тэргүүлэх үүрэг гүйцэтгэх орон болох чиг хандлага илэрч байна.

### **Дөрөв. Нүүрснээс олон төрлийн бүтээгдэхүүн гаргаж авах, ашиглах төслүүд нь ойрын хугацаанд хамтран ажиллах гол салбар**

Монголын нүүрсний нөөц асар их, 2015 оны эцсийн байдлаар, хайн тогтоосон нөөц 25.8 тэрбум тонн байж, дэлхийд 10-т ордог.<sup>208</sup> Үүнд хүрэн нүүрс нь голдуу төв, зүүн бүсэд тархаж, бүхнийг ил аргаар олборлож болох бөгөөд гаазан хий, бензин, дулаан цахилгаан станц байгуулах, нүүрс, химийн үйлдвэр байгуулахад тохиромжтой. Одоохондоо Монголын эрчим хүчний хэрэглээнд байгалийн хий болон нүүрсний хийн ашиглалт маш бага, өмнөд болон баруун хойд бүсийн цахилгаан хангамж импортод түшиглэж байна. Монголын хүн амын тал орчим хувь төвлөрсөн Улаанбаатар хотыг авч үзэхэд өвлийн улирал урт мөртлөө гэр хорооллууд нүүрс түлэх, хотын буруу төлөвлөлтөөс шалтгаалан агаарын бохирдол өндөр байна. Монголын засгийн газраас шахмал түлш, цэвэр зуух хангах арга хэмжээ авсан ч үр дүн нь тийм сайнгүй байсаар байна.

Хятад бол байгалийн хийн хэрэгцээний том улс, 2006 оноос импортолж, импортын хэмжээ жил дараалан нэмэгдэж, одоогоор 60 тэрбум куб метр<sup>209</sup> дөхөж

<sup>206</sup> Гэхдээ Монгол улсын хөрөнгө оруулалтын банкны тухай хууль хараахан батлагдаагүй.

<sup>207</sup> 《中国对外投资合作发展报告(2016)》正式发布(附全文)  
[http://www.360doc.com/content/17/0402/16/32488356\\_642333953.shtml](http://www.360doc.com/content/17/0402/16/32488356_642333953.shtml)

<sup>208</sup> Монгол улсын ашигт матмал газрын тосны газар, 2015 оны 12 сарын мэдээлэл, [EB/OL].  
[http://mram.gov.mn/mram\\_new/images/stories/mram/statistek](http://mram.gov.mn/mram_new/images/stories/mram/statistek)

<sup>209</sup> 盘点 2014 年中国天然气进口量, <http://wenku.baidu.com>

байна. Хятад бол нүүрс хийжүүлэх тэргүүний технологи эзэмшсэн улсын нэг байж, эдийн засгийн шинэ бодлогын хүрээнд стандартыг дээшлүүлэх, мэргэшсэн аж ахуйн нэгж “гадаадад гарах”-ыг урамшуулах бодлого хэрэгжүүлж байна. Ийнхүү “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор” байгуулах үйл явц нь энэхүү төрлийн хамтын ажиллагааг бий болгох буюу өмнө нь зогсоод байсан төслийг идэвхжүүлсэн байна.

2013 оны 10-р сард Монгол улсын ерөнхий сайд Хятадад айлчлах үеэр Sinores-тэй нүүрс хийжүүлэх төслийн хэлэлцээр байгуулав. Энэ нь Монголд жилд 50-80 сая тонн нүүрсээр 15 тэрбум шоо метр хий үйлдвэрлэх, 30 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалттай төсөл юм. Тус төсөл нь хэд хэдэн нүүрсний уурхайд түшиглэн олборлох, дамжуулах хоолой байгуулах, бүтээн байгуулалтын хугацаанд 40 мянган ажлын байр хангах, ашиглалтанд орсны дараа 10 мянган ажлын байр хангах, үйлдвэрлэсэн хийгээр Улаанбаатар хотыг хангахаас гадна (урьдчилсан байдлаар, Монголын нүүрсэн хийн хэрэгцээ 2 тэрбум куб метр), дийлэнх хэсгийг Хятадад экспортлох юм байна. Нэгэн үе зогсонги байдалд орсон тус төсөл нь 2015 оны 11 дүгээр сарын Монгол улсын ерөнхийлөгчийн Хятадад хийсэн айлчлалын хамтарсан мэдэгдэлд ахиулах төслөөр тусгагдав.<sup>210</sup>

2005 онд эхэлж яригдсан Шивээ-Овооны ДЦС-н төсөл нь хэсэг хугацаанд зогсонги байснаа 2014 оноос Монгол талын санаачлага доор, Хятадын Улсын цахилгаан сүлжээ корпорацитай яриа хэлцэл өрнүүлж, 2015 оны эхээр Монгол улсын Эрчим хүчний яамны төлөөлөгчид Хятадын цахилгаан сүлжээ корпорацид айлчилж, Шивээ-Овоо төслийн Хятад, Монголын хамтарсан ажлийн хэсэг байгуулах, тус төслийг цогцоор ахиулах талаар тохиролцоонд хүрэв.

Хятадын улсын цахилгаан сүлжээ корпораци төслийн талбайн хил өөрчлөгдсөн байдлыг харгалзан, төслийн нэмэлт ТЭЗҮ-г хийж дуусгахдаа, мөн цахилгаан дамжуулах хүчдэлийн зэрэглэл, хэмжээний талаар тохиролцоонд хүрсний үр дүнд, 2015 оны 11 дүгээр сард Монгол улсын ерөнхийлөгч Хятадад айлчлах үеэр, Хятадын Улсын цахилгаан сүлжээ корпораци болон Монгол улсын Эрчим хүчний яам хооронд “Шивээ-Овоо нүүрс цахилгааны цогцолборт техник, эдийн засгийн судалгаа хамтран хийх хэлэлцээр” байгуулав. Төсөл нь Хятад-Монголын цахилгаан сүлжээний холболтын анхны төсөл байж, Хятад, Монголын хамтарсан мэдэгдэлд тэргүүлэх төслөөр тусгагджээ. Хэлэлцээрийн дагуу, улсын цахилгаан сүлжээний эрчим хүчний компани гол гүйцэтгэгчийн хувиар Шивээ-Овоо төслийн нүүрсний уурхай, цахилгаан станцын ажлыг хариуцна. Тус төсөлд жилийн олборлох хэмжээ 34 сая тонн ил нүүрсний уурхай, 14 x 660 МВт-ын суурилагдсан хүчин чадал бүхий ДЦС, 8000 МВт-ын дамжуулах хүчин чадал бүхий ±800 кВ-ын HVDC цахилгаан дамжуулах агаарын шугам зэрэг ажлууд багтана.<sup>211</sup>

Дээрх төслүүдийн хэрэгжилт нь Хятадын хувьд, байгалийн хий, цахилгаан зэрэг цэвэр эрчим хүчний хангамжид бас нэгэн ойр дөхөм, тогтвортой нийлүүлэгчтэй

<sup>210</sup> 蒙缓步推进中蒙煤制气等大型能源项目 -- 中华人民共和国驻蒙古国大使馆经济商务参赞处, <http://mn.mofcom.gov.cn>

<sup>211</sup> 国网节能公司扎实推进中蒙锡伯敖包煤电输一体化项目前期工作 - 国家电网公司, <http://www.sgcc.com.cn>, 2015.11.03.

болж, эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Монгол улсын хувьд, нөөцийн давуу талаа эдийн засгийн давуу тал болгон хувьчлах, цэвэр эрчим хүчинтэй болох, эрчим хүчний хэрэглээний бүтцийг сайжруулах, хотын оршин суугчдын амьдрах орчныг сайжруулахын зэрэгцээ, томоохон хэмжээний тогтвортой ажлын байрыг ханган, төсвийн болон төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх болно.

**Тав. Дэд бүтэц, боомтын бүтээн байгуулалт болон усны нөөцийн хуваарилалт нь чухал болох урьдчилсан буюу нэмэлт хөрөнгө оруулалтын чиглэл болох**

Монгол улсын дэд бүтцийн хөгжил тааруу байж, хатуу хучилттай автозамын бүтээн байгуулалт сүүлийн жилүүдэд эрчимтэй явагдсан ч нийт автозамын 20 хувь хүрэхгүй байна. 2015 оны төмөр замын тээврийн хүчин чадал 35.82 сая тонн,<sup>212</sup> Монгол улс түүхий эдийг их хэмжээгээр экспортлох шаардлагыг яасан ч хангахгүй байна. 2010 онд баталсан шинэ төмөр замын төлөвлөгөө болон 2014 оны 10 дугаар сард баталсан хоёр чиглэлийн нарийн царигийн зам нь үндсэндээ бэлтгэл шатандаа явагдаж байгаа. Сүүлийн үед Хятад, Монгол, Оросын гурван талт хамтын ажиллагааны төслийн хүрээнд Монгол улсын дамжин өнгөрөх тээврийн Монгол Улсын квотыг нэмэгдүүлэх тохиролцоо нь энэхүү ачааллын дарамтыг нэн ихэсгэсэн байна. Одоогийн Хятад, Монголын 16 хилийн боомтын дэд бүтцийн нэвтрүүлэх хүчин чадал, аж ахуйн нэгжийн худалдааны хэрэгцээтэй нэлээд зөрүүтэй байгаа нь өнөөгийн бодит байдал юм.

Усны нөөцийн хомсдол нь Монголын уул уурхайн ашиглалтын ирээдүйд нэн тулгамдсан асуудал болж магад. Монголын уул уурхайн нөөц ихтэй өмнөд говийн бүсэд гадаргын ус нь хүн малын хэрэгцээг хангахад хүрэлцэхгүй учир уул уурхайн хэрэгцээнд зөвхөн гүний усыг хэрэглэхээс өөр арга байхгүй. Монгол эрдэмтдийн тооцооллоор, одоогийн уурхайн ордын гадаргын ус болон гүний усны ашиглалтын харьцаа 1:9 энэ нь усны эргэлтийн тэнцвэрийг алдагдуулжээ. Харин гүний усны бүрэлдэн төлөвших мөчлөг нь 1400 жил орчим богино хугацаанд сэргээгдэхэд бэрх. Үүнээс үүдэн зарим эрдэмтдээс “Умардын усыг өмнө зүгт татах” санал дэвшүүлсэн байна<sup>213</sup> гэхдээ энэ нь бол хөрөнгө маш их зарцуулах төсөл бөгөөд, Монголын засгийн газар дангаараа гүйцэтгэж дийлэхгүй юм.

Эдгээр урьдчилсан буюу нэмэлт бүтээн байгуулалтын олонх нь ААН-ийн хүчин чадлаас хэтийдэж, засгийн газраас гардан хийх концесс буюу, ТХХТ зэрэг горимоор хийх шаардлагатай. Ийнхүү дэд бүтэц, боомт, усны нөөцийн хуваарилалтын бүтээн байгуулалтын салбарт хөрөнгө санхүүжүүлэх, хамтран ажиллах бол хоёр орны эдийн засгийн коридор байгуулахын чухал урьдчилсан буюу нэмэлт хөрөнгө оруулалтын чиглэл болно.

<sup>212</sup> Монгол улсын үндсний статистикийн хороо, <http://www.1212.mn/statHtml/statHtml>.

<sup>213</sup> Д.Шүрхүү, монгол-хятадын эрчим хүч, зам тээврийн харилцаа хамтын ажиллагаа, “хятад орос монголын 5-р форум”, Бээжин, 2014.05.15.



## **Зургаа. Сэргээгдэх эрчим хүчний салбарын хамтын ажиллагаа нь эрчим хүчний хамтын ажиллагааны ирээдүйн чиглэлийг тодорхойлно.**

Аж үйлдвэрийн хувьсгалаас хойш чулуужсан түлшийг урт хугацааны туршид их хэмжээгээр ашигласны улмаас эрчим хүчний хангамжийн аюулгүйн ноцтой байдал, байгаль орчны бохирдол, уур амьсгалын өөрчлөлт зэрэг сөрөг үр дагаварыг бий болгосон байна. Сэргээгдэх эрчим хүчний байнга ашиглаж болох нөөцийн шинж чанар нь түүний тогтвортой хөгжлийн эрчим хүчний эзлэх байр суурийг тодорхойлж, харин түүний цэвэр, бараг тэг ялгаруулах байдал нь байгальд ээлтэй давуу тал юм. Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх бол чулуужсан эрчим хүчний хэрэглэг сааруулах, байгаль орчны бохирдол, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх, бага нүүрстөрөгчийн эрчим хүчний шилжилтийг биелүүлэх, эрчим хүчний хангамжийн аюулгүй байдлыг батлахын чухал санаачлага болсон ба бүтээмжтэй арга зам юм. Хятад нь “Парисын гэрээ”-ний үзэглэгч, томоохон эрчим хүчний хэрэглэгчийн хувьд шинэ хэвийн байдлын эдийн засагт, эрчим хүч хэмнэх, эрчим хүчний хэрэглээний бүтцээ сайжруулах шинэ стратеги хэрэгжүүлж эхэлсэн байна.

Монгол улс нь сэргээгдэх эрчим хүчний хөгжлийн дэлхийн чиг хандлага, уул уурхайн хөгжлийн явцад илэрсэн байгаль орчны асуудал, өөрийн орны экологийн шинж байдалтай уялдуулан, 2012 онд баталсан "говийн бүсийн сэргээгдэх эрчим хүчний төсөл"-д, салхи, нарны зэрэг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглаж, 2020 он гэхэд эрчим хүчний хэрэглээний бүтцэд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 20-25 хувьд хүргэх зорилтыг дэвшүүлсэн байна.<sup>214</sup>

Монгол улсын салхины эрчим хүч, нарны эрчим хүчний нөөц асар их. АНУ-ийн Сэргээгдэх эрчим хүчний үндэсний лабораторийн тоо баримтыг үндэслэвэл Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 71 хувьд салхины эрчим хүчийг хөгжүүлж болно. Нутаг дэвсгэрийн хагасаас илүү талбайд, жилийн салхины хурд 3.5m/c-ээс их хугацаа 4000/цаг-аас багагүй байж, салхины эрчим хүчний суурилагдах хүчин чадал 1100GW байна. Нарны эрчим хүчний эх үүсвэр ойролцоогоор 5 TW, нарны эрчим хүчний ашиглах боломж дэлхийд 3-т ордог. Монгол улсын шинэ Харилцаа холбооны корпораци, АНУ-ын General Electric компанитай хамтран байгуулсан Монголын анхны “салхит” салхины цахилгаан станц 2013 онд ашиглалтад орсон. Тус СЦС-ийн хүчин чадал жилд 140-170 мега ватт байж, энэ нь Монгол улсын цахилгаан эрчим хүчний хэрэглээний 5 хувьтай тэнцэнэ. Үүнээс гадна, малчдын гэр ахуйд өргөн хэрэглэгдэж байгаа аль олон гэр ахуйн жижиг салхин цахилгаан аппаратууд (50W) бий.<sup>215</sup>

Монгол улсын сэргээгдэх эрчим хүчийг ашиглах талаар, Японы дэвшүүлсэн “Азийн мега сүлжээ”<sup>216</sup>, Хятад, Солонгос, Монгол гурван тал хамтран дэвшүүлсэн

<sup>214</sup> 2015-2020 年蒙古国的能源投资研究报告 [R/OL]. 新能源资讯\_中国新能源网. <http://www.china-nengyuan.com/news/71296.html>.2016-04-20.

<sup>215</sup> 2015 年蒙古国际电力建设及新能源技术设备展会, <http://www.geo-show.com>, 2014.12.03.

<sup>216</sup> 借鉴欧洲沙漠光伏计划日本提建“亚洲超级电网” [EB/OL].OFweek 太阳能光伏网. <http://solar.ofweek.com/2012-03/ART-260006-8130-28603564.html>.

“Говь цөлийн мега сүлжээ”<sup>217</sup> хөтөлбөрүүд бий.

“Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор” байгуулах тохиролцоо, Хятад, Монголын нүүрс цахилгаан, нүүрс хийжүүлэх төслийн үйл явц нь эдгээр төслийг дахин зөвшилцөх халуун асуудал болгов. Ер нь сэргээгдэх эрчим хүчний хил дамнасан дамжуулалтад эрх зүй, техник, стандарт зэрэг саад их байдаг. АСЕАН-ны эрчим хүчний сүлжээ, ЕХ-ны эрчим хүчний сүлжээний олон жилийн практик туршлагаас харахад, “Говь цөлийн мега сүлжээ”, “Азийн мега сүлжээний” ирээдүйн замын зурагт 50 алхам байж болох магадлалтай. Үүнд: нэгт, үндэсний эзэмшил эрхийг хуваалцах ажлыг эхлүүлж, тэр түвшинд зөвлөлдөх механизмыг бий болгох, байнгын солилцоо өрнүүлэх. Хоёрт, төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг олох. Гуравт, төслийн судалгаа, үнэлгээ хийх. Үүнд эрсдэлийн, байгаль орчны, нийгмийн үнэлгээг багтаана. Мөн төслийн дизайнд тохируулалт хийх. Дөрөвт, дээд түвшний засгийн газар хоорондын хамтын ажиллагааны зөвшилцөлд хүрч, цахилгаан хэрэглэх гэрээнд гарын үсэг зуран, ирээдүйн үйл ажиллагаа, засвар хамгаалалтын тогтолцоог тогтоох. Тавд, төлөвлөлт тогтоон, газар дээр нь туршилт хийж, үлгэр жишээний төсөл хэрэгжүүлэх.<sup>218</sup>

Монгол улсын асар их сэргээгдэх эрчим хүч, Зүүн Хойд Азийн асар их эрчим хүчний эрэлт хэрэгцээ, Хятадын эдийн засгийн шинэ хэвийн байдал бол Хятад-Монгол болон бүс нутгийн сэргээгдэх эрчим хүчний салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэх хүчтэй түлхэц мөн. Түүнчлэн дээрх зарим төслүүд хэрэгжиж эхэлсэн ба АСЕАН болон ЕХ-ны бэлэн туршлага зэрэг нь сэргээгдэх эрчим хүчний хамтын ажиллагааг Хятад, Монголын эрчим хүчний хамтын ажиллагааны ирээдүйн тэргүүлэх чиглэл гэж үзэх онол, практикийн бүрэн үндэслэлтэй.

**Долоо. Хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагаа улам бүр чухалчлагдан, ирээдүйн том цар хүрээтэй бүс нутгийн хамтын ажиллагаа болон чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахад үлгэр жишээ үүрэг гүйцэтгэх болно.**

2010 оны 6 дугаар сард Хятадын Ерөнхий сайд Вэнь Жябао Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр, Хятад Монголын ЧХХ-н техник, эдийн засгийн судалгааг эртхэн эхлүүлэхийг санал болгож, мөн хэд хэдэн удаагийн хэлэлцээр хийсэн байна. 2014 оны 8 дугаар сард Ши Жиньпин дарга Монгол Улсад айлчлах үеэр, хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай хэлэлцээрт гарын үсэг зурж, 2015 оны 3 дугаар сард Хятад Монголын хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах ажлын хэсгийн анхны зөвлөлдөх уулзалт Эрээн хотноо зохион байгуулагдаж, хоёр тал тус тус 9 хавтгай дөрвөлжин км газар гарган, хамтаар хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тохиролцоонд хүрсэн. 2015 оны 6 дугаар сарын 9-нд Өвөр Монголын

<sup>217</sup> 张琰. “风”从亚洲来|韩国|济州岛 [J/OL]. 《瞭望东方周刊》. 2014 (17) \_凤凰 [http://news.ifeng.com/a/20140505/40154782\\_0.shtml](http://news.ifeng.com/a/20140505/40154782_0.shtml).

<sup>218</sup> 瞭望: “亚洲超级电网”能实现吗 [N/OL]. 联合早报网. <http://www.zaobao.com/wencui/politic/story20131016-265224>.

Худалдааны танхимын дарга Монгол Улсад айлчилж, Монголын Аж үйлдвэрийн яамны дэд сайдтай уулзах үеэр, Хятадын тал 6 дугаар сарын 18-нд барилгын ажлаа эхлүүлэхийг албан ёсоор мэдэгдэж байсан.<sup>219</sup>

Хятад, Монголын хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах нь худалдаа, хөрөнгө оруулалт, татварын тогтолцоо, санхүүгийн үйлчилгээ, хил нэвтрэх удирдлага, газрын менежментийн талаар урьдчилсан байдлын туршилт явуулж, түүний зорилго нь тогтолцоо, механизмын шинэчлэлээр дамжин, хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд худалдаа, хөрөнгө оруулалтын либералчлал, хөнгөвчлөлийг биелүүлэхэд оршино.<sup>220</sup>

Энэ нь Хятад, Монголын стратегийн хамтын ажиллагаа болон худалдаа, эдийн засгийн харилцааг бэхжүүлэх, “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор”-ын чухал түшиц бий болгох, хил орчмын тогтвортой хөгжил, нээлтийн туршилтын шинэ загварыг судлах, орон нутгийн аж үйлдвэрийн бүтцийг сайжруулах болон ажлын байр бий болгох, хоёр орны хамтын ажиллагааны агуулга, хэлбэрийг цэгээс талбайд тэлэх, бүс нутгийн интеграцыг ахиулахад ихээхэн үлгэр жишээ суурь үүрэг гүйцэтгэх болно.

Үүнээс гадна, Хятад Монголын хил дамнасан аялал жуулчлалын хамтын ажиллагааны бүс байгуулах зэрэг ажлууд мөн хийгдэж байгаа бөгөөд эдгээр хоёр орны янз бүрийн орон нутгийн бодит байдалд тохирсон, харьцангуй жижиг талбайн туршилтын хамтын ажиллагаа нь эрсдэлийг орон зайн хувьд багасгаж, түүнчлэн боловсронгуй болсны дараа үе шаттайгаар дэлгэрүүлж болох уян хатан чанартайгаас гадна улс хоорондох хамтын ажиллагааны нийтлэг хэлбэрийн нэг юм.

Ер нь Хятадын эдийн засгийн шинэ хэвийн байдал нь олон улсын эдийн засгийн харилцаанд тусгалаа олж, Хятад, Монголын эдийн засгийн хамтын ажиллагаанд шинэ ойлголт, үзэл баримтлал хэрэгжихийн хэрээр шинэ түлхэц болж, хамтын ажиллагааны гол салбар, чиглэл, загварын чиг хандлагыг тодорхойлж байгаа билээ.

<sup>219</sup> Аж үйлдвэрийн яамны дэд сайд Өвөрмонголын Худалдааны танхимын даргыг хүлээн авч уулзав, <http://oloo.mn/2015.06.10>.

<sup>220</sup> 二连浩特中蒙跨境经济合作区建设概要介绍\_二连浩特市人民政府网站 [http://www.elht.gov.cn/tzel/zsxn/yhzc/201507/t20150706\\_72945.html](http://www.elht.gov.cn/tzel/zsxn/yhzc/201507/t20150706_72945.html).

## НОМ ЗҮЙ

1. 习主席在河南考察时首次明确提出新常态 - ROM 之家官网
2. <http://www.romzj.cn/news/games/168/20160305/48932/>
3. 什么是中国经济新常态，经济新常态的特征\_百度知道
4. <http://zhidao.baidu.com/question/1048073506864384339.html>.
5. 中国经济外交新常态之一：经济外交开启中国范式 - 国际频道 - 新华网
6. [http://news.xinhuanet.com/world/2014-12/25/c\\_1113771608.htm](http://news.xinhuanet.com/world/2014-12/25/c_1113771608.htm)
7. 习近平在蒙古国国家大呼拉尔发表重要演讲 -- 时政 -- 人民网
8. <http://politics.people.com.cn/n/2014/0823/c1024-25522723.html>
9. Монгол улсын гаалийн ерөнхий газар, 2015 оны 12-р сарын гадаад худалдааны эмхтгэл, Online Statistic Information System.[http://mram.gov.mn/mram\\_new/images/stories/mram/statistek/2015/monthly\\_report\\_2016.01.04.pdf](http://mram.gov.mn/mram_new/images/stories/mram/statistek/2015/monthly_report_2016.01.04.pdf).
10. Монгол улсын ашигт малтмал газрын тосны газар, 2015 оны 12 сарын мэдээлэл,[EB/OL].
11. [http://mram.gov.mn/mram\\_new/images/stories/mram/statistek](http://mram.gov.mn/mram_new/images/stories/mram/statistek)
12. 盘点 2014 年中国天然气进口量, <http://wenku.baidu.com>
13. 蒙缓步推进中蒙煤制气等大型能源项目 -- 中华人民共和国驻蒙古国大使馆经济商务参赞处, <http://mn.mofcom.gov.cn>
14. 国网节能公司扎实推进中蒙锡伯敖包煤电输一体化项目前期工作 - 国家电网公司 <http://www.sgcc.com.cn>, 2015.11.03.
15. Д.Шүрхүү, монгол-хятадын эрчим хүч, зам тээврийн харилцаа хамтын ажиллагаа, “хятад орос монголын 5-р форум”, Бээжин, 2014.05.15.
16. 2015-2020 年蒙古国的能源投资研究报告\_新能源资讯\_中国新能源网 <http://www.china-nengyuan.com/news/71296.html>.2016-04-20.
17. 2015 年蒙古国际电力建设及新能源技术设备展会, <http://www.geo-show.com>, 2014.12.03.
18. 借鉴欧洲沙漠光伏计划 日本提建“亚洲超级电网”. OFweek 太阳能光伏网
19. <http://solar.ofweek.com/2012-03/ART-260006-8130-28603564.html>.
20. 张琰.“风”从亚洲来|韩国|济州岛.《瞭望东方周刊》.2014(17)\_凤凰网 [http://news.ifeng.com/a/20140505/40154782\\_0.shtml](http://news.ifeng.com/a/20140505/40154782_0.shtml)
21. 瞭望：“亚洲超级电网”能实现吗.联合早报网
22. <http://www.zaobao.com/wencui/politic/story20131016-265224>.
23. Аж үйлдвэрийн яамны дэд сайд Өвөрмонголын Худалдааны танхимын даргыг хүлээн авч уулзав, <http://olloo.mn/2015.06.10>.
24. 二连浩特中蒙跨境经济合作区建设概要介绍\_二连浩特市人民政府网站
25. [http://www.elht.gov.cn/tzel/zszn/yhzc/201507/t20150706\\_72945.html](http://www.elht.gov.cn/tzel/zszn/yhzc/201507/t20150706_72945.html)